МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2019 оны 09 сарын 11 өдөр Дугаар А-239 Улаанбаатар хот

Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн
хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг тогтоох тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 19[1] дүгээр зүйлийн 1, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Зээлийн мэдээллийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ 5,000,000,000.00 (таван тэрбум) төгрөгөөр, Монголбанкнаас зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгох ажил, үйлчилгээний шимтгэлийг 5,000,000.00 (таван сая) төгрөгөөр тус тус тогтоосугай.

2.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зээлийн мэдээллийн алба (С.Ганбаяр)-нд үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАЯРТСАЙХАН

14 1839

Tushaal 2019.doc